

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багахангай Тохижилт ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/82/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Б энд С аудит ХХК-ийн захирал Д.Заяажаргал
Утас: 99050268 Цахим хаяг: bcauditllc@gmail.com

Ахлах аудитор: Ц.Жамъянхорол
Утас: 95282528 Цахим хаяг: bcauditllc@gmail.com

Аудитор: Б.Нарантуяа
Утас: 99194168 Цахим хаяг: bcauditllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15

№

499

танай _____-ны № _____-т

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багахангай Тохижилт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“БАГАХАНГАЙ ТОХИЖИЛТ”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.ГЭРЭЛМАА ТАНАА

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	54,381,237.97	31,480,763.18
1.1.2	Дансны авлага	25,256.63	7,200.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	134,545.46	161,703.30
1.1.6	Бараа материал	64,558,614.52	65,630,896.73
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		274,967.83
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	119,099,654.58	97,555,531.04
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,203,863,390.94	1,018,254,796.52
1.2.2	Биет бус хөрөнгө	124,834,800.00	124,042,800.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,328,698,190.94	1,142,297,596.52
1.3	Нийт хөрөнгийн дүн	1,447,797,845.52	1,239,853,127.56
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	1,542,800.00	2,054,380.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		1,815,558.41
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,542,800.00	3,869,938.41
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,542,800.00	3,869,938.41
	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч		
2.3.1	-төрийн	2,343,274,834.51	2,335,891,977.11
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	116,944,800.00	116,944,800.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг		-1,312,858,537.66
	Тайлангийн үеийн ашиг	-1,312,858,537.66	-202,888,998.97
	Өмнөх үеийн ашиг	298,893,948.67	298,893,948.67
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,446,255,045.52	1,235,983,189.15
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	1,447,797,845.52	1,239,853,127.56

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	547,723,813.43	746,026,272.72
2	Борлуулалтын өртөг	598,105,266.05	654,760,733.81
3	Нийт ашиг (алдагдал)	-50,381,452.62	91,265,538.91
10	Ерөнхий ба удирдлагын зардал	205,881,352.71	265,930,229.10
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	12,167,784.46	28,224,308.78
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-268,430,589.79	-202,888,998.97

19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-268,430,589.79	-202,888,998.97
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-268,430,589.79	-202,888,998.97
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-268,430,589.79	-202,888,998.97
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,571,340,392.14	298,893,948.67	116,944,800.00	(1,043,786,230)	1,943,392,911
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(268,430,590)	(268,430,590)
5	Өмчид гарсан өөрчлөлт	-228,065,557.63				(228,065,558)
8	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,343,274,834.51	298,893,948.67	116,944,800.00	(1,312,216,820)	1,446,896,763
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(641,718)	(641,718)
2	Залруулсан үлдэгдэл	2,343,274,834.51	298,893,948.67	116,944,800.00	(1,312,858,538)	1,446,255,046
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(202,888,999)	(202,888,999)
4	Бусад дэлгэрэнгүй орлого					
5	Өмчид гарсан өөрчлөлт	(7,382,857.40)				(7,382,857)
8	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,335,891,977.11	298,893,948.67	116,944,800.00	(1,515,747,537)	1,235,983,189

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	605,495,999.00	821,318,485.65
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	15,441,257.00	42,814,500.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,198,898.00	2,402,381.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	572,866,300.00	715,027,747.01
1.1.6	Бусад мөнгөн орлого	15,989,544.00	61,073,857.64
1.2	Мөнгөн зарлагын дүн	735,910,207.38	798,168,960.44
1.2.1	Ажиллагчдад төлсөн	310,382,995.94	363,146,239.13
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	85,477,941.13	102,661,078.09
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	140,613,281.70	111,016,192.50
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	55,197,996.52	64,634,833.09
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	50,749,399.00	51,169,200.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	71,125,677.19	92,516,862.63
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	958,950.00	1,206,135.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	21,403,965.90	11,818,420.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(130,414,208.38)	23,149,525.21
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн		46,050,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		46,050,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(46,050,000.00)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн		
3.2	Мөнгөн зарлагын дүн		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(130,414,208.38)	(22,900,474.79)
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	184,795,446.35	54,381,237.97
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	54,381,237.97	31,480,763.18

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Санхүүжилтын орлого	694,622.4	715,027.7	20,405.3	102.9
2	Бараа борлуулж үйлчилгээ үзүүлсний орлого	10,000.0	42,814.5	32,814.5	428.1
3	Шинэ жилийн үйл ажиллагаа		50,000.0	50,000.0	-
4	Нохой устгалын санхүүжилт		8,376.0	8,376.0	-
5	Бусад		2,697.9	2,697.9	-
6	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		2,402.4	2,402.4	-
	Нийт борлуулалт	704,622.4	821,318.5	111,595.8	116.6
1	Үндсэн болон нэмэгдэл цалин	429,177.8	432,725.9	3,548.1	100.8
2	НД, ЭМДШимтгэлийн зардал	51,679.6	54,398.9	2,719.3	105.3
3	Цахилгааны зардал	3,600.0	2,255.2	(1,344.8)	62.6
4	Түлш, шатахууны зардал	24,232.8	44,546.3	20,313.5	183.8
5	Шатах тослох материал	3,288.7	3,525.0	236.3	107.2
6	Халаалтын зардал	9,120.0	12,677.0	3,557.0	139.0
7	Түрээсийн зардал	44,882.4	44,882.3	(0.1)	100.0
8	Элэгдлийн зардал	223,077.3	223,404.1	326.8	100.1
9	Халтиргаа, гулгаа	2,000.0	3,057.0	1,057.0	152.9
10	Урсгал засвар	29,647.6	78,467.2	48,819.6	264.7
11	Тээврийн хэрэгслийн оношилгоо	240.0	240.0	-	100.0
12	Авто машины татварт	661.0	661.0	-	100.0
13	Цэвэр бохир усны зардал	216.0	199.8	(16.2)	92.5
14	Шуудан холбооны зардал	1,082.4	939.0	(143.4)	86.8
15	Хөдөлмөр хамгааллын зардал	18,039.5	15,730.1	(2,309.4)	87.2
16	Бичиг хэргийн зардал	3,034.6	3,849.3	814.7	126.8
17	Нэг удаагийн буцалтгүй тусламж	2,400.0	3,442.0	1,042.0	143.4
18	Газрын төлбөр	82.6	114.5	31.9	138.6
19	Сургалтын зардал	170.0	170.0	-	100.0
20	Даатгалын зардал	1,206.0	1,206.1	0.1	100.0
21	Үндсэн хөрөнгө худалдаж авах зардал	5,368.2	-	(5,368.2)	0.0
22	Тэтгэврийн тэтгэмж	3,360.0	3,360.0	-	100.0
23	Ариутгалын зардал	750.0	750.0	-	100.0
24	Аудитын төлбөр	5,700.0	3,700.0	(2,000.0)	64.9
25	НӨАТ-ын зардал	51,715.0	-	(51,715.0)	0.0
26	Бусад зардал	7,000.0	14,614.5	7,614.5	208.8
	Нийт зардал	921,731.5	948,915.3	27,183.8	102.9
	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(217,109.1)	(127,596.8)	84,412.1	58.8
	Татварын зардал				
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(217,109.1)	(127,596.8)	84,412.1	58.8
	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	92.2	22.2	(70.0)	24.0
	Авлага	0	168.9	168.9	
	Өглөг	0	3,869.9	3,869.9	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,405.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1,405.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,405.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,756.5 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Байгууллагын дарга тушаал шийдвэргүйгээр илүү цагийн хөлс авсан	1	1,405.0	1	1,405.0									
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2019 оноос хойш шинэчлэн боловсруулаагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн байгуулах хугацаа буруу байна.	1						1						
Дүн	2	1,405.0	1	1,405.0			1						

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.